

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.03.07 - 2022.03.11/

2022.03.11

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ НҮБ-ын "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь" санаачлагын хүрээнд "Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх аргачлал"-ын дагуу хийх ерөнхий үнэлгээний цахим сургалтад хамрагдсан. ✓ "ГАЗ ОЙЛ НЕФТЬ" ХХК-ний барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэний дагуу холбогдох барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн барилга байгууламжаа ашиглалтад оруулаагүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчилтэй байсан тул ашиглалтад оруулах боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн. ✓ Дархан сумын 9-р иргэн Г.Галавсэнгийн үйлчилгээний зориулалттай барилгад барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн албан хүсэлттэй танилцаж газрын зориулалтын дагуу биш байсан тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн. ✓ Дархан сумын хэмжээнд барилгын нүх ухсан, түр хашаа татсан байршлуудын судалгааг гаргаж Аймгийн ЗДТГазарт хүргүүлсэн.
2	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Шар усны үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан аймгийн Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэгт багтсан ЗАА, ОБГ, МХГ, сумдын тамгийн газрын дарга нартай Дархан сум, Орхон сум, Шарын гол сум, Хонгор сумдуудад үерийн ус болох эрсдэлтэй цэгүүд дээр газар дээр нь очиж үзлэг шалгалт хийсэн.
3	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> ✓ Ногоон Дархан 2032 төслийн байршлын зураг ✓ Архитектур төлөвлөлтийн даалгавар 2-г боловсруулж батлуулсан ✓ Эскиз зураг 2-г хянаж баталгаажуулав ✓ Газар Зохион байгуулалт геодези зураг зүйн газраас зохион байгуулсан 21 аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан Газрын нэгдмэл сангийн цахим систем, Төрийн өмчийн газрын мэдээллийн сан, хаягжуулалтын мэдээллийн системийн талаарх чадавхжуулах сургалтанд 2022.03.09-2022.03.11ны хооронд хамрагдсан
Газрын удирдлагын хэлтэс		
1	Кадастр, геодези, зураг зүйн чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 6 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 6 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 10 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн. ✓ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од", "Ёлт сүрвэй" ХХК-ний хийж гүйцэтгэсэн ✓ Үйлчилгээтэй 63-н айлын орон сууцны барилга ✓ "Баян бридж" ХХК-ны нийтийн орон сууц ✓ Гахайн аж ахуйн гадна 6кв, 0.4 кв цахилгааны шугамын ✓ гүйцэтгэлийн ажлыг шалгаж хүлээн авсан. ✓ Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 221800056, 221800057, 221800058, 221800082, 221800095, 221800113 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг хүргүүлсэн. ✓ Багуудын оноосон нэрийг аймгийн болон сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тогтоол

		гаргуулах ажлын хүрээнд багуудын нэрийг сумын Засаг даргын зөвлөл болон сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж санал дүгнэлтээ ирүүлэхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн.
2	Газрын төлөв байдлын хянан баталгаа, газрын мониторингийн чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ 2 иргэнд “Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны мэдэгдэх хуудас” хэвлэж өгсөн. ✓ Захиалгат хянан баталгааны 4 тайланг Газрын мониторингийн системд хянаж баталгаажуулсан, 1 тайланг хянаж буцаасан. ✓ Хянан баталгаа, мониторингийн системийн цахим сургалтанд хамрагдсан
3	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 2 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн. ✓ 2022 оны 01-А/51 тоот захирамжаар 6 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшүүлэх гэрээ, гэрчилгээг цахимд үүсгэж ажилласан.
4	Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэл	✓
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Хүний нөөц, дотоод асуудал, хууль эрх зүй	<p>Хүний нөөц:</p> <ul style="list-style-type: none"> ✓ “Хөдөлмөрийн дотоод журам”, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр 2022-2026”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 2022-2026”, “Хүнийн нөөцийн хөгжлийн стратегий хөтөлбөр 2022-2026” “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө 2022”, “ Сургалт, хөгжлийн төлөвлөгөө 2022”, “ хөгжлий бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулхаар төслийг боловсруулсан. ✓ 2022/03/9-03-11-ний хооронд УБ хот, Газрын цахим биржийн төвд зохион байгуулагдах сургалтад ХБКЗТМХМэргэжилтэн Дарьсүрэнг хамруулсан. <p>Шүүх Хуралдаан:</p> <ul style="list-style-type: none"> ✓ О.Соёлмаа нарын нэхэмжлэлтэй, гуравдагч этгээдийн сөрөг нэхэмжлэлтэй хариуцагчаар ГХБХБГ-оролцсон 2022/01/13 дугаар 62 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхий Магадлалаар 2021/11/01-ний өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Дугаар 16 шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах гомдлыг хангаагүй болно. ✓ Дархан Ти Ви ХХК-ний нэхэмжлэлтэй хариуцагчаар Аймгийн ЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах оролцсон 2022/02/10-ны өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 114/ ШШ2022/0002 шийдвэрийг эс зөвшөөрч, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны дагуу холбогдох тайлбарыг боловсруулж байна.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: Байгууллагын Facebook хуудсанд ирсэн 5 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсний Үйл ажиллагааны тайлан хэсэгт байгууллагын 1,2-р сарын 7 хоног, сарын тайлангуудыг байрлуулав. Мөн Зарлал хэсгийг Санал хүсэлт болгон өөрчилж санал гомдол хүлээн авах зурган линк үүсгэн байрлуулав. Байгууллагын Facebook хуудсанд цахим хуудасны санал, гомдол хүлээн авах хэсгийн холбоосыг QR код үүсгэн байрлуулав.</p> <p>Нярав:Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 3 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов. Шаардах хуудсаар 2 төрлийн 3 ширхэг бараа материал олгов. 2021 оны 9-12-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв.</p>

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж